



**“ТЭСО” ХХК-ИЙН “ХИМИЙН ЛАБОРАТОРИ” ТӨСӨЛ  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



**БАТЛАВ:**

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА:

/Б.БУЯННЭМЭХ/

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“ТЭСО” ХХК-ийн гүйцэтгэх захирал

/ С.БОЛОР /

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
18-Р ХОРООНД БАЙРЛАХ “ТЭСО” ХХК-ИЙН “ХИМИЙН ЛАБОРАТОРИ”  
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ХЯНАСАН:**

ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

/П.ШИНЭЦЭЦЭГ/

**БОЛОВСРУУЛСАН:**

“ТЭСО” ХХК-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ  
БОДЛОГЫН МЕНЕЖЕР:

/Т.СУВДАА /

Улаанбаатар хот  
2023 он

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

### Төсөл хэрэгжүүлэгч, хуулийн этгээдийн товч мэдээлэл

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр	“ТЭСО” ХХК
	Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Химийн лаборатори
	Захиралын нэр, утас, цахим шуудан	С.Болор
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудан	Т.Сувдаа, 88105955 , environmental-manager@teso.mn
1.2	Төслийн нэр	Химийн лаборатори
	Төслийн харъяаллын байршил	СХД-н 18-р хороо 21-р хороолол
	Төслийн ангилал	Хамааралгүй
	Төсөл эхэлсэн огноо	2009
	Төсөл хэрэгжих хугацаа	-
	Уурхайн хаалт эхлэх огноо	Хамааралгүй
	Хаалтын дараах зориулалт	Хамааралгүй
	ТЭЗҮ батлагдсан огноо	Хамааралгүй
	Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ	-
	Ажилчдын тоо	8
	Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	-
	Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	Хамааралгүй

### Химийн бодисын эрсдэл, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл
3.1	Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ	
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө <ul style="list-style-type: none"> <li>- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ</li> <li>- Эрсдлийн үед авах арга хэмжээ</li> <li>- Учируулах хор хөнөөлийг бууруулах зайлуулах арга хэмжээ</li> <li>- Хохиролыг нөхөн төлөх арга хэмжээ</li> </ul>	
3.2	- Шатах тослох материалын нэр төрөл	
	- Тэсрэх, дэлбэрэх бодисын нэр төрөл	
3.3	Тухайн жилийн хог хаягдлын дундаж хэмжээ <ul style="list-style-type: none"> <li>- Ахуйн хаягдал</li> <li>- Үйлдвэрийн хаягдал</li> <li>- Аюултай хаягдал</li> </ul>	
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн төсөв	1220.0мян.төг

**Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2022 оны төсөв**

№	Мэдээлэлийн төрөл	Мэдээлэл /мян.төг/
4.1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	8.932.0
	Нөлөөллөөс урьдачлан сэргийлэх арга хэмжээний төсөв	1.130.0
	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	
	Нөхөн сэргээх, ногоон байгууламж арга хэмжээний төсөв	3.500.0
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	-
	Нөлөөллийн бүс дэхь оршин суугчидад тайлагнах төсөв	-
	Удирдлага зохион байгуулалтын төсөв	350.0
	Нүүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэх төлөвлөгөөний төсөв	-
	Орчны хяналт шинжилгээний нийт төсөв	714.0

**Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт**

Байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	Тоо	Шалгуур үзүүлэлтийг тооцсон эсэх	Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тооцсон эсэх	Дүгнэлт
Нөлөөллөөс урьдачлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	7	Тийм	Тийм	
Нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
Нөхөн сэргээлт	-	-	-	
Дүйцүүлэн хамгаалах	-	-	-	
Оршин суугчидад тайлагнах	1	Тийм	Тийм	
Түүх соёлын өвийг хамгаалах	-	-	-	
Удирдлага зохион байгуулалт	1	Тийм	Тийм	

**Орчны хяналт шинжилгээний хяналтын хуудас**

Хяналт шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж	Төсөв
Хөрс	2	Хашааны гадна хогийн цэгийн орчим, үүдний зогсоол орчим	Жилд 2	150.0мян.төг
Ус	1	Үйлдвэрийн хаягдал усны хоолой	Улиралд 1	450.0мян.төг
Амьтан	-	-	-	-
Ургамал	-	-	-	-
Агаар	3	Агуулахын байранд 2, гадна талбайд 1	Жилд 2	114.0 мян.төг

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хороонд байрлах “Тэсо” ХХК-ийн дэргэдэх химийн лаборатори нь 2009 онд анх уг байгууллагын салбар үйлдвэрийн бүтээгдэхүүн, түүхий эдэд чанарын сорилт шинжилгээ хийхээр байгуулагдсан өдийг хүртэл ашигийн бус зөвхөн хүнсний үйлдвэрүүдийн эцсийн бүтээгдэхүүн түүхий эдэд хими, микробиологийн шинжилгээ хийн ажилладаг байна.

“Тэсо” ХХК нь хүнсний үйлдвэрлэлээрээ хэрэглэгчдийн найдвартай түнш байхыг эрхэм зорилгоо болгон хэрэглэгчдийн гарт чанарын өндөр түвшинд бэлтгэж боловсруулсан стандартын шаардлага хангасан эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхийн тулд дотоодын хяналтын лабораторийн химийн бодисын ашиглалт, хадгалалт, бодис урвалжийн дүнд үүсэх уусмал, химийн бодисын сав баглаа боодлыг байгаль орчинд халгүй аргаар хэрхэн устгах арга хэмжээг төлөвлөх, шийдвэрлэх түвшинд хэлэлцэх зүй ёсны шаардлага байдгийг уг байгууллага нь холбогдох хуулийн дагуу хэрэгжүүлдэг.

Тэсо ххк салбар үйлдвэрүүдийн дэргэдэх дотоодын хяналтын лабораторит 71 төрлийн химийн бодис, микробиологийн лабораторийн олон тэжээлт орчныг ашиглан салбар үйлдвэрүүдээс үйлдвэрлэн гаргаж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг шинжилдэг байна.

Лабораторийн тоног төхөөрөмж, боловсон хүчний чадавхийг улам бүр сайжруулан “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” MNS ISO/IEC 17025:2007 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж 2013 оны 1 сард Стандарт Хэмжилзүйн Газраас анх итгэмжлэгдсэн. 2014 оны 12 сарын 09-нд давтан итгэмжлэгдсэн.

### **Химийн лабораторийн хүчин чадал:**

Тус лаборатори нь бүх төрлийн хүнс, ундны ус, ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэгт сард дунджаар 1000-1500 дээжинд хими микробиологийн шинжилгээ хийдэг.

Лаборатори нь 8 мэргэжлийн химич, микробиологичтойгоор жилийн дөрвөн улирал ажилладаг.

Химийн бодисыг химийн бодис худалдах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс худалдан авч ханган нийлүүлдэг.

### **1.2 Төслийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл**

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт орших “Тэсо” ХХК-ийн “Химийн лаборатори”-ийн төсөл нь Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороолол 18080 үйлдвэрийн эвлэлийн гудамж, 53/3 тоот хаягт байршилтай “Милко” ХХК-ийн үйлдвэрлэл агуулахын зориулалттай 5100 м.кв газар дээр баригдсан барилгын нэг давхарт 368 м.кв лабораторийн үйл ажиллагааг явуулдаг байна. Химийн лаборатори төсөл нь ажлын байрыг түрээсээр эзэмшиж үйл ажиллагаа эрхэлдэг. *Түрээсийн гэрээг тайланд хавсаргав.* Мөн дараах эрх зөвшөөрөл, орон нутгийн санал авсан байна. Үүнд:

- ✓ “Тэсо” ХХК
- ✓ Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011034132
- ✓ Регистрийн дугаар 2293463
- ✓ БОАЖЯ-ны 2020 оны 06-р сарын 16-ны өдрийн 13/4418 дугаартай Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт;
- ✓ Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2020 оны 04-р сарын 22-ны өдрийн 05/842 тоот дугаартай санал;
- ✓ Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны Иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, хуралдааны тэмдэглэл

### 1.3 Төслийн талбайн байгаль орчны төлөв байдал

#### 1.3.1. Төслийн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт “Милко” ХХК-ийн үйлдвэрлэл, агуулахын зориулалттай газар дээр баригдсан 4 давхар ажлын байрны нэг давхарт түрээсийн нөхцөлтэйгээр ажлын байрыг эзэмшиж байна. Уг талбайгаас чанх урд зүгт 0.5 км-ийн зайд Таван шарын автобусны буудал, зүүн хойд зүгт 0.62 км-ийн зайд Содон хороолол, зүүн талд 0.25 км-ийн зайд 21-р хорооллоос Дрогон чиглэлийн авто зам байрласан байна.

Зураг. Төслийн талбайн байршилын агаар, сансрын зураг



**Газрын гадаргуу:** Улаанбаатар хот нь газарзүйн байршилын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1292.4-1412.8 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан байна. Харин газрын гадаргын хэвгий буюу налуу  $0-4.7^{\circ}$  (градус)-т байна.

**Усан сүлжээ:** Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Хойд мөсөн далайн ай сав, Туул голын сав газарт тус тус багтана. Сонгинохайрхан дүүрэг нь Туул голын дунд хэсгийн дунд талын хэсэгт оршдог. Энэ хэсэгт чанх хойноос Толгойтын салааны гол болон Толгойтын зүүн салааны гол нийлэн урсаж судалгааны талбайн араар тойрон далангаар урсаж Сэлбэ голд цугаж цаашлаад Туул гол цутгах ба хот дотор далангаар тусгаарлагдсан байдаг.

**Цаг агаар, уур амьсгал:** Улаанбаатар хотын уур амьсгалын төрхийг ерөнхийд нь хоёр хувааж үзэж болно. Үүнд Уулархаг хэсгийн уур амьсгал, Туул голын хөндийн уур амьсгалын гэсэн ялгарал үүсч байна. Сонгинохайрхан дүүрэг буюу Уулархаг хэсгийн уур амьсгал нь уур амьсгалын мужлалтаар чийглэгдүү хүйтэвтэр зунтай, хахир өвөлтэй мужид багтдаг бол Туул голын хөндийн уур амьсгал нь хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй мужид багтана. Үнэмлэхүй их температур нь  $-49^{\circ}\text{C}$  бол үнэмлэхүй халуун температур нь  $+39^{\circ}\text{C}$  байна. 1 дүгээр сарын дундаж температур  $-25^{\circ}\text{C}$ , 7 дугаар сарын дундаж температур  $+15^{\circ}\text{C}$  байна. Олон жилийн дундаж температур нь  $-2^{\circ}\text{C}-0^{\circ}\text{C}$  хооронд байна. Нэн халуун өдрийн тоо буюу  $+30^{\circ}\text{C}$  дээш байх өдрийн тоо 20-30 өдөр байна. Нэн хүйтэн өдрийн тоо буюу  $-30^{\circ}\text{C}$  доош температуртай өдрийн тоо 30-40 байна. Агаарын хоногийн дундаж температур  $+10^{\circ}\text{C}$  ба түүнээс дээш байх өдрийн тоо хотын нутгийн талбайн зүүн хойд хэсгээр 75-90 бол бусад хэсгээр 90-120 байна.

Жилд унах хур тунадасны хэмжээ Туул голын эхээр буюу хотын нутгийн зүүн хойд хэсгээр 400-500 мм, хотын нутгийн төв хэсгээр 300-400 мм ба харин хотын нутгийн баруун хэсгээр (Сонгинохайрхан уулаас баруун зүгт) 250-300 мм байна. Өвөлдөө хотын зүүн хойд хагаст 11 дүгээр сарын 10-наас 15-ны хооронд цас тогтож эхлээд, 3 дугаар сарын 20-ноос 4 дүгээр сарын 1-ний хооронд хайлж эхэлнэ. Хотын баруун өмнөд хагаст цас тогтох хугацаа арай богино буюу 11 дүгээр сарын 15-наас 20-ны хооронд тогтож, 3 сарын 10-наас 20-ны хооронд ханзарч эхэлнэ. Туул голын орчмын ууршилт 250 мм-ээс дээш бол уулархаг хэсгийн ууршилтын хэмжээ 200-250 мм байна. Агаарын чийгшил 1-р сардаа хотын нутгийн зүүн хойд хагаст 75%-иас дээш бол баруун урд хагаст 55-65% орчимд байна. Агаарын чийгшил зуны улиралдаа буюу 7 дугаар сард Туул голоос хойш 60-70% байдаг бол голоос урагш 50-60% байна. Шороон шуурга шуурах нь улсын нутгийн өмнөд хэсгийг бодоход харьцангуй бага, хотын нийт нутгийн хэмжээнд жилийн дундаж нь 30 хүртэлх өдөр байна.

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн талбайн район нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн муж, Хэнтийн төвийн тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009). Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд бүхэлдээ уулын хар хүрэн хөрс тархсан. Судалгааны талбай бүхэлдээ хүний нөлөөлөлд өртсөн суурин газар болсон.

**Ургамлан нөмрөг:** Монгол орны ургамал-газар зүйн мужлалаар Сонгинохайрхан дүүрэг орчмын нутгийг Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамааруулдаг (Өлзийхутаг, 1989) боловч энэ нутаг Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог ба Дундад Халхын хуурай хээрийн тойргийн зааг дээр оршдог учраас уулын хээр ба жинхэнэ хээрийн хэвшлийн ургамалжилтыг хосолсон шинж чанартай байна. Төслийн талбайд хялгана хиаг алаг өвт бүлгэмдэл тархах унаган хэвшинжтэй боловч судалгааны хашаалсан талбай 100 хувь хатуу хучилтай байна.

**Амьтны аймаг:** Сонгино хайрхан дүүрэг орчмын нутаг бол манай орны ойт хээрийн бүсэд хотжилтын бүсэд хамаарна. Хотжилтын нөлөөгөөр хүнд ойромсог амьтад амьдарна.

**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:** Сонгинохайрхан дүүрэг нь хотын баруун хэсэгт, Сонгинохайрхан уулын бэлд оршдог бөгөөд 1200.6 км<sup>2</sup> газар нутагтай ба нийслэлийн Баянгол, Хан-уул дүүргүүд, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Баянцогт сумдуудтай хиллэн оршдог. Өдгөө засаг захиргааны 32 хороо, 71747 өрхийн 277312 хүн амтай, 56107 толгой малтай нийслэлийн томоохон дүүргийн нэг болжээ. Дүүрэг нь Монгол улсын хүн амын 9.6 хувь, Улаанбаатар хотын хүн амын 21.8 хувь, газар нутгийн 25.5 хувийг тус тус эзлэн оршиж байна.

## БҮЛЭГ 2. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах зардлыг тусгасан. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүний хэрэгжүүлэх арга зүй, хугацаа, давтамж, шаардагдах зардлыг тусгасан.

БОМТ-г боловсруулахдаа 2019 оны 10-р сарын 29-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журмыг удирдлага болгов.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:**

- БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болсон байна.
- Ажилтан ажиллагсад нэг бүр байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд үүргээ биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалтанд хамрагдсан ур чадвартай мэргэжилтэнтэй болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг урьдчилсан тооцсноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалж, хамгаалах
- Химийн лаборатори төслийн үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам, зааврыг байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандартын шаардлагад нийцүүлнэ.
- Дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллана.
- Байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөллийг багасгах талаар ажиллагсдад зааварчилгаа өгч гарын авалга материалаар хангах
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх

БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12-р сарын 01-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

### Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Тэсо” ХХК-ийн “Химийн лаборатори” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага хэдий ч химийн бодистой харьцаж ажиллах, урвалж уусмал бэлдэх явцад лабораторийн дотоод агаарт хортой бодис тархаж түүгээр амьсгалах, ажиллагсад бодис урвалжид түлэгдэх, хордох зэрэг нөлөөллүүд гарч болзошгүй.



Хүснэгт. Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хугацаа	Тоо хэмжээ	Нэгж үнэ, мян.төг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Хууль эрх зүйн шаардлага
1.	Агаарт хорт бодис тархах	Хүнсний хими, микробиологийн лабораторид дотоод агаарын бохирдол үүсэх, дээж бэлтгэх өрөөний агаараас тогтмол дээж авч ажиллах, хяналтын тогтолцоог бий болгох	Химийн лаборатори	2023 онд	тогтмол	100.0	100.0	Төсөл хэрэгжүүлэгч	Хяналтын тогтолцоо бий болно	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль <b>MNS4585:2016</b> Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, <b>MNS5885:2008</b> Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. <b>MNS4990:2015</b>
2.		Лабораторийн агааржуулалтыг хянах төхөөрөмжтэй болох, гарах агаарыг шүүлтүүрээр дамжуулах, тогтмол ажиллуулах	Химийн лаборатори	2023 он	тогтмол	-	-	Төсөл хэрэгжүүлэгч		Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.
3.		Лаборатори руу давхар хаалгаар зөвхөн зөвшөөрөгдсөн ажилчид нэвтрэх, агаар эргэж урсахгүй байлгах	Үйл ажиллагааны туршид	-	-	-	-	Тэмдэглэгээ хийж, лабораторийн ажиллагсад мөрдөх		
Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал						100.0 мян.төг				

Хүснэгт. Төслөөс газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж үнэ, мян.төг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Хууль эрх зүйн шаардлага
1,	Төслөөс гарах ахуйн хаягдлаар хөрс бохирдох	Газрын хөрсөн дээр хог хаягдал хаягдахаас сэргийлэх, тогтоосон цэгт хурааж, зайлуулах	Химийн болон нян судлалын лаборатори	-			Экосити-селекшиг-ххк	Ахуйн хог хаягдлыг зайлуулсан байна.	Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль Хог хаягдлын тухай хууль Ариун цэврийн тухай хууль MNS 6260 : 2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS5850:2008. “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
2.	Химийн бодис урвалж, нянгийн хаягдлаар хөрс бохирдох	Химийн бодис урвалжийг тусгай саванд хадгалах	Физик химийн үзүүлэлт тодорхойлох лаборатори	-	450.0	450.0	Аюултай хог хаягдал цуглуулах мэргэжлийн байгууллагад хүргүүлэх	Хөрс нефтийн бүтээгдэхүүнээр бохирдохоос сэргийлнэ.	
3.	Нянгийн бохирдлоор хөрс бохирдох	Петрийн аяганд ургуулсан нянгийн бохирдлыг тусгай саванд хадгалах	Нян судлалын лаборатори	7 хоногт нэг удаа зөөвөрлөх	380.0	380.0	Аюултай хог хаягдал устгах “Элемент” ХХК	Аюултай хог хаягдал аюулгүй устгагдаж хөрс бохирдохоос сэргийлсэн байна.	
<b>Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал</b>					<b>830.0 мян.төг</b>				

Хүснэгт. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө



Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хугацаа	Тоо хэмжээ	Нэгж үнэ, мян. төг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Хууль эрх зүйн шаардлага
Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах	Угаалтуур дээр мэдрэгчтэй цорго суурилуулах	Төвлөрсөн эх үүсвэрээс татах хэсэгт	2023 онд	1 ш	-	-	Төсөл хэрэгжүүлэгч, Ус сувгийн удирдах газар	Усыг хэмнэлттэй ашиглана.	Ус ашиглалт хэрэглэг тоолууржуулах журам, Усны тухай хууль Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах үйлчилгээний хөлс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль Ундны ус.Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт MNS 0900:2015 -MNS 6148:2010 “Усны чанар. Газар доорх усыг бохирдуулагч бодисын ЗДХ” MNS 4943 - 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
Төлбөр хураамж	Усны нөөц ашигласны төлбөр төлөх	Тоолуурын заалт	2023 онд	Сар бүр	-	-	Төсөл хэрэгжүүлэгч	гарна.	
	Ус бохирдуулсны төлбөр төлөх	СХД-ээс ус бохирдуулсны төлбөр төлөх зөвшөөрөл авах	2023 онд	-	-	-	Төсөл хэрэгжүүлэгч, Сонгинохайрхан дүүргийн ажлын алба	Ус бохирдуулсны төлбөр төлнө.	
	Бохирдуулагч бодис бүрээр хаягдал усанд шинжилгээ хийх	Усны химийн лабораторид шинжлүүлнэ	2023 онд	Улирал бүр	200.0	200.0	Төсөл хэрэгжүүлэгч, Монгол ус төрийн өмчит үйлдвэрийн үйлдвэрийн газрын усны химийн лабораторитой хамтран ажиллах	Төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг бууруулах, засвар шинэчлэлд бодитой хөрөнгө оруулалт хийсэн байна.	
<b>Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал</b>				<b>200.0 мян.төг</b>					

Хүснэгт. Ажиллагсадын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, норм норматив
Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгаа зөрчсөнөөс хүний эрүүл мэнд, амь насанд аюул учрах	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болох ХАБЭА-н талаар сургалт зохион байгуулах	Лабораторийн ажиллагсад	200.0	200.0*1=1000.0	2020-2025	<b>MNS 5566 : 2005</b> Гал түймрээс хамгаалах. Аж ахуйн нэгж, Байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм.
	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тогтмол хамруулж байх.	Лабораторийн ажилчид 8 хүн	150.0 <sup>1</sup>	8*150*1 жил=6000.0	2020-2025	
	Ажиллагсдын байранд эмийн сан байршуулах, анхны тусламж үзүүлэх	Лабораторийн бүсэд	50.0	50.0	2020-2025	<b>MNS (ISO) 13688 : 2000</b> Хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд тавигдах шаардлага.
	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	“Тэсо” ХХК-ийн 8 хүн	40.0	8*40.0*1 жил=1600.0	2020-2025	
	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэжээ /Хөдөлмөрийн аюулгүй байдлын булан, санамж, плакат, галын булан	Химийн лаборатори	-	Санхүүгийн дотоод зардал	2020-2025	
	ХАБЭА-н дүрэм зааврыг мөрдөж ажиллах	Лабораторийн ажилчид	-	-	2020-2025	
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал 1 жилийн урьдчилсан зардал</b>				<b>1770.0 мян.төг</b>		

<sup>1</sup> Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10-р сарын 10-ны өдрийн 340 дугаар тушаалын 1-р хавсралт “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-д зардлыг тооцов.

Хүснэгт . Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Үе шат	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж үнэ, мян. төг	Нийт зардал мян. төгрөг	Хэрэгжүүлэгч	Хууль эрх зүйн шаардлага
1.	Үерийн аюул, хур тунадас	Зун, намрын улиралд үргэлжилсэн буюу их устай бороо орох, үйл ажиллагаа саатах	Үерийн далан хаалтын бүрэн бүтэн байдлыг хангах, засварлах, хог хаягдлыг цэвэрлэх	Төслийн талбайн хэмжээнд	Судалгааны талбайн хойд хэсгээр	115.0	115.0	Төслийн үйл ажиллагааны явцад	
2.	Цахилгааны аюулгүй ажиллагаа	Үер, салхи шуурга, газар хөдлөлөөс цахилгаан тасрах, гэмтэх, осол үүсэх	Цахилгааны хэлбэлзэлтэй үед тэжээлээс автоматаар салгагддаг байх,	Химийн лаборатори	-	Дотоод зардал	-	  	MNS 6010:2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага MNS 4996:2000 Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага
3	Галын аюулгүй ажиллагаа	Талбайн тоног төхөөрөмжийн гэмтэл, шалбарсан утас, цахилгааны хэлбэлзэл, цахилгааны эх үүсвэрийн хүчдэл хэлбэлзэх	Тоног төхөөрөмжийн гэмтлийг тухай бүр нь засах, цахилгааны утсыг шалгах, цахилгааны хүчдэл өөрчлөгдөх автоматаар тэжээлээс салгагддаг байх	Химийн лаборатори	-	Дотоод зардал	-		
		Гал гарахаас сэргийлэх	Галын хорын булан, галын хор байрлуулах <sup>2</sup>	Химийн бодисын агуулах болон бусад газруудад	3	133.0	133.0		
5	Хөдөлмөр хамгаалал	Ажлын байрны хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаагүйгээс ажиллагсадын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Хөдөлмөр хамгааллыг БОННУ-ний тайлангийн 7-р бүлэгт заасан зөвлөмжийг хэрэгжүүлэх	Лаборатрийн ажиллагсал	8	Зардлыг хөдөлмөр хамгааллын зардалд тусгах			
6	<b>Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал</b>					<b>248.0 мян.төг</b>			

<sup>2</sup> Галын хорын үнийн саналыг “Сокол” ХХК-иас авав.

### ***Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө***

Тус төслийн үйл ажиллагааны явцад байгалийн унаган байдалд оруулахааргүй онц ноцтой бохирдол, хор нөлөө гарахгүй учир дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага гараагүй болно.

### ***Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө***

"Тэсо" ХХК нь түрээсээр Милко ХХК-ийн химийн лабораторит түрээсээр үйл ажиллагаа явуулдаг тул нүүлгэн шилжүүлэлт хийж магадгүй.

### ***Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө***

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед "Монгол Улсын Үндсэн хууль"-ийн I бүлгийн 7-р зүйлд "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна" гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

### ***Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө***

"Тэсо" ХХК-ийн химийн лабоарторийн үйл ажиллагааны үед ажилчдын ахуйн хог хаягдал, аюултай хог хаягдал болох нянгийн үлдэгдэл аюултай хог хаягдал, бодис урвалжийн аюултай хог хаягдал, шил сав угаасан шингэн хог хаягдал гарна. Төслийн үйл ажиллагааны үед гарсан хог хаягдлыг байгаль орчинд бохирдол багатайгаар зайлуулах, ангилан ялгах дахин ашиглах асуудлыг зохицуулахад менежментийн төлөвлөгөөний зорилго оршино. Ахуйн лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулах нь зүйтэй. Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгуулагад хүлээлгэн өгч мэргэжлийн түвшинд устгуулах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь БОАЖСайлын А/21 тушаалын Хавсралт 3. Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлангийн маягт, Хавсралт 5. Аюултай хог хаягдал цуглуулах үйл ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягтын дагуу тустус бүртгэлийг хөтөлж ажиллана.

Хүснэгт. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур
Хог хаягдлын түр хадгалах ангилан ялгах цэг байгуулах	Талбайн хэмжээнд	ш	1	1000.0	1000.0	Лабораторийн эрхлэгч	Хог түр хадгалах, ангилан ялгах цэгтэй болсон байна.
Ажилчдын байранд хогийн сав байрлуулж, хогийг ангилан ялгуулж байх	Талбайн хэмжээнд	ш	5	10.0	50.0	Захиргаа	Экологийн боловсрол эзэмшинэ.
Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга анамж бүхий самбар, тэмдэгжүүлэлттэй болгох	Талбайн хэмжээнд	ш	4	20.0	80.0	Захиргаа	Хяналтын талбайг цэвэрлэх
Хуурай хог хаягдалд болгоомжгүй үйлдлээс болон аль нэг шалтгаанаар гал гарах үед ашиглах гал унтраагуур, элс, хүрз бэлэн байлгах	Хог хаягдлын түр хадгалах цэгт	ш	Галын булан 2ш	45.0	45*2 ш=90.0	Лабораторийн эрхлэгч	Хог хаягдал ангилан ялгах, түр хадгалах байгууламжийн дэргэд
Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэхийн тулд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Талбайн хэмжээнд	Удаа	Сард 2	Дотоод төлөвлөлтөөр		БО хамгаалах алба	Орчин тогтмол цэвэрхэн байх
Хог түр хадгалах цэгт төвлөрсөн хогийг зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх	Талбайн хэмжээнд	Удаа	Сард 2	20.0	Дотоод зардал	БО хамгаалах алба	Албан ёсны зөвшөөрсөн цэгт зөөдөг байх
Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Талбайн хэмжээнд	Удаа	Сард 1	10.0	Дотоод зардал	БО хамгаалах алба	Ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн бүртгэл байна
Химийн лабораториос үүсэх химийн бодис урвалжийн хаягдал Нян судлалын лаборатриос гарах хаягдал	Химийн лаборатори Нян судлалын лаборатори	Удаа	7 хоногт нэг удаа	Дотоод төлөвлөлтөөр		Лабораторийн эрхлэгч	Аюултай хог хаягдал устгах мэргэжлийн байгууллагаар устгуулах
							Биологийн аюултай хог хаягдал устгах “Элемент” ХХК-ийн тусламжтайгаар устгах
<b>Нийт дүн</b>				1220.0			

### БОМТ түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОННУ, түүнд үндэслэн боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг БОАЖЯ-наас олгоно. Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ батлагдсанаас хойшхи ашиглалтын жил бүр төсөл тус бүр дээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хариуцан боловсруулж БОАЖЯ-нд хүргүүлнэ. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ батална.

#### Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

*Хүснэгт. Оролцогч талуудад тайлагнах хуваарь*

№	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хаана тайлагнах болон хэлэлцүүлэх	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа
1	Дүүргийн иргэдэд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	Тайлагнах	Жил бүрийн БОМТ-ний хэрэгжилт үр дүнгийн тайлан	Жил бүр
2	Нийслэлийн байгаль орны газарт БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	Тайлагнах	Жил бүрийн БОМТ-ний хэрэгжилт үр дүнгийн тайлан /биелэлтийн тайланг дүгнүүлэх/	Жил бүрийн 11.01ний дотор
3	БОАЖЯ-ны ХБОБНУ-ын газарт	Батлуулах	БОМТ-г батлуулах	Жил бүрийн 12 сард



Хүснэгт .Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах стандарт
Тухайн жилийн БОМТ-г боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг тайлагнах	Химийн лаборатори	удаа	1	Дотоод төлөвлөлтөөр		БО хамгаалах алба	Мэргэжлийн байгууллага	БОМТ батлагдсан, хэлэлцүүлэг хийгдсэн, тайлагнасан байна	БОНХ-ийн сайдын 2014.01.06-ны өдрийн А-05
- Байгаль орчин хамгаалах - Хөдөлмөр хамгаалал зэрэг сэдвээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Бүх ажилтан	удаа	2	250.0	250.0	Төсөл хэрэгжүүлэгч	Мэргэжлийн байгууллага	Сургалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл	-
Байгаль орчны хөндлөнгийн аудит хийлгэх	Химийн лаборатори	удаа	2 жилд 1 удаа	Дотоод төлөвлөлтөөр		"Тэсо" ХХК	Мэргэжлийн байгууллага	Аудит хийгдсэн байна	БОХ тухай хууль
Үйл ажиллагааны зардлаар Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын тухай хууль, журам, стандартын биелэлтийг хангах зорилгоор дотоод хяналтыг зохион байгуулах	Химийн лаборатори	удаа	5	Дотоод төлөвлөлтөөр		Лабораторийн эрхлэгч	Мэргэжлийн байгууллага	Шалгалтын үр дүнг илтгэсэн тайлан	БОХ тухай хууль
- Гал түймрээс урьдчилан сэргийлэх -Хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны салбар гаргаж байрлуулах	Химийн лаборатори		3	100.0	100.0	Лабораторийн эрхлэгч	-	-	Тухайн хуулиуд
<b>Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтэнд байнга хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах</b>	Төлөвлөгөөний хүрээнд	удаа	2022	Дотоод төлөвлөлтөөр		"Тэсо" ХХК	БОАЖЯ, Орон нутгийн удирдлага	Хяналт, шалгалт хийсэн байна.	БОХ тухай хууль
<b>Нийт дүн</b>				<b>350.0</b>					

## **Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдлага болгов. Үүний дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын явцад орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

## **Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардал**

Тухайн төслийн хэрэгжүүлснээр үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ<sup>3</sup>-н харьяа БОХЗТЛ<sup>4</sup>-ийн үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

<sup>3</sup> Ус Цаг Уур Орчны Хяналт Шинжилгээний Газар

<sup>4</sup> Байгаль Орчны Хэмжил зүйн Төв Лаборатори

Хүснэгт . Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

д/д	Хяналт үзүүлэлт	Байршил, цэгийн тоо	Давтамж	Хууль, бодлого, стандарт	Хариуцах эзэн	Хамтран хэрэгүүлэгч	Биелэл-тийн шалгуур	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг
<b>Агаар</b>									
Агаар орчин	PM10, PM2.5 тоос	1.Төслийн гаднах талбайд -1 цэг 2.Химийн лаборатори доторх агаар 3.Нян судлалын лаборатори	Жилд 2 удаа	MNS 5885:2008 MNS 4585:2016 MNS 6063:2010 MNS 5002:2000	Төсөл хэрэгжүүлэгч	БОХТЛ	Шинжилгээний дүн	32,0	64,0
	NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> CO, Нийт тоос тодорхойлох, Дуу чимээ, шуугиан, доргио		Жилд 1 удаа					50,0	50,0
	Агаар дахь хүнд элементүүд /14 элемент/								
<b>Хөрсөн бүрхэвч</b>									
Хөрс бохирлол	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд	1.Төслийн талбайд хог хаягдлын цэг	Жилд 2 удаа	-	Төсөл хэрэгжүүлэгч	ГЗГЭХ-ийн Хөрс судлалын лаборатори	Шинжилгээний дүн	25,0	50,0
	Хүнд элементин шинжилгээ /8 элемент/		Жилд 2 удаа	MNS 5850:2019	Төсөл хэрэгжүүлэгч	БОХТЛ	Шинжилгээний дүн	50,0	100,0
<b>Ус</b>									
Усан орчин бохирдох	Ерөнхий хими	- Төвлөрсөн эх үүсвэрийн оролт дээр-1 -Бохир усны гаралт дээр -1 /Бохирдуулагч бодис тус бүрээр/	Жилд нэг удаа	1.Усны чанар эрүүл ахуйн стандарт MNS 900-2018.	Төсөл хэрэгжүүлэгч	Монгол ус Төрийн өмчит үйлдвэрийн газар	Шинжилгээний дүн	50,0	50,0

	Хүнд элементийн шинжилгээ		Улирал бүр удаа	2. Байгаль орчин, аялалжуулчлалын сайдын 2019.09.27-ны өдрийн А/543 дугаар тушаал . “Ус бохирдуулах аюултай бодисын жагаалт”			Шинжилгээний дүн	100.0	400.0
Жилд зарцуулах мян.төг	зардал	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 сард багтаан БОАЖЯ-нд тайлагнах нь зүйтэй						714.0 мян.төг	

### Нөхөн сэргээлт, орчны тохижилтын төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм. "Химийн лабортори"-ийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан моджуулах ажлыг БОННУ-ний тайлан тусгасан зөвлөмжийн дагуу тарих шаардлагатай.

Ер нь газрын нөхөн сэргээлт гэдэг нь "эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ" юм.

Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болсон байна.

### ОРНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Хэрэгжих байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал /мян.төг/
Үйлдвэрийн орчны тохижилт, ажилчдын амрах саравч	Оффиссын гадна талбай	жилд нэг удаа	500,000
Цэцэрлэгжүүлэлт, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Ногоон байгууламж дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ /арчилгаа тордолгоо/	Жил бүр	3,000,000
<b>2023 оны нийт зардал</b>			<b>3,500,000</b>

Хүснэгт. Байгаль орчны менежментийн 5 жилийн төлөвлөгөө"-ний нэгдсэн дүн

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал /мян.төг/ 5 жил	Тухайн жил БОМТ
		2020-2025 он	Зардал /мян.төг/ 2023 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах	Агаарын чанар -500.0 мян.төг	1.130.0 мян.төг
		Хөрс -6810.0 мян.төг	
		Ус – 3220.0 мян.төг	
		Нийт- 10530 мян.төг	
2	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө	8850.0 мян.төг	1.770.0 мян.төг
3	Нөхөн сэргээлт, ногоон байгууламж	7140.0 мян.төг	3.500.0 мян.төг
4	Осол эрсдлийн төлөвлөгөө	974.0 мян.төг	248.0 мян.төг
5	Дүйцүүлэн хамгаалах	“Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй.	
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	“Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө” тусгайлан боловсруулах шаардлагагүй.	
7	Түүх, соёлын өвийг хамгаалах	“Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй.	
8	Хог хаягдлын менежмент	3020.0 мян.төг	1.220.0 мян.төг
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4640.0 мян.төг	714.0 мян.төг
10	Байгаль орчны аудит, удирдлага	3000.0 мян.төг	-
11	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын менежмент	4000.0 мян.төг	350.0 мян.төг
<b>БОМТ-ний 5 жилийн зардал</b>		<b>42154.0 мян.төг</b>	<b>8.932.0 мян.төг</b>

Дүгнэлт:

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 18-р хорооны нутагт хэрэгжиж буй “Тэсо” ХХК-ийн “Химийн лаборатори” төслийн 2020-2025 он хүртэл 5 жилийн БОМТ-г БОАЖЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал нь **8.932.0** мянган төгрөг төлөвлөлөө. Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, нөхөн сэргээлт, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.